



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12.1.3, 13.1, 13.2, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.5, 2.6, 2.7, 3.8-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж дүгнэлт гаргах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ёс зүйн дэд хороог албан хаагчдын олонхын саналд үндэслэн дараах бүрэлдэхүүнтэйгээр 5 жилийн хугацаатай байгуулсугай:

Дарга:	Э.Одмөнх	Төрийн ёслолын газрын дарга
Гишүүд:	Д.Үржинсүрэн	Төрийн захиргааны удирдлагын газрын Засгийн газрын ахлах референт;
	О.Дөлгөөнтуул	Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын референт;
	Б.Очирпүрэв	Салбар дундын уялдааг зохицуулах хэлтсийн ахлах шинжээч;
	Б.Төрбат	Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч;
	Б.Мөнхбилгүүн	Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын ахлах шинжээч.
Нарийн бичгийн дарга:	З.Гэрэлт-Од	Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч

2. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Э.Одмөнх)-д даалгасугай.

3. Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улирал бүр урамшуулал олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ж.Бямбасүрэн)-т зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Ёс зүйн дэд хороо байгуулах тухай" Тэргүүн дэд даргын 2023 оны 248 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.СОЛОНГОО

0025300187